



I-IV/2022

Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 13




Улсын хэмжээнд 129.5 мянган мал хорогдсон байна

Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 30.8 сая хээлтэгч малын 20.2 сая (65.7%) нь 2022 оны эхний 4 сард төллөсөн байна. Эм хонины 72.4 хувь, эм ямааны 68.4 хувь, үнээний 34.1 хувь, ингэний 29.4 хувь, гүүний 24.1 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.4 хувь буюу 19.9 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 4.4 (28.2%) саяар өссөн байна.

Зураг 1. ТӨЛ БОЙЖИЛТ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, төрлөөр, хувиар



Том малын зүй бус хорогдол 2022 оны эхний 4 сард улсын хэмжээнд 129.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (91.2%) саяар буурсан байна. Харин 2022 оны 4 дүгээр сард 62.3 мянган мал хорогдсон нь эхний 4 сарын хорогдсон малын 48.1 хувийг эзэлж байгаа бол 3 дугаар сард хорогдсон малаас 27.4 (78.6%) мянгаар өссөн байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 55.1 мянга, хонь 54.1 мянга, үхэр 12.3 мянга, адуу 7.8 мянга, тэмээ 156-аар хорогдсон байна. Нийт хорогдсон малын 42.6 хувийг ямаа, 41.8 хувийг хонь эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

| Малын төрөл | Хорогдсон том мал | | | | Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь | | | |
|-------------|-------------------|--------------|----------------|--------------|---|-------------|-------------|-------------|
| | 2019 I-IV | 2020 I-IV | 2021 I-IV | 2022 I-IV | 2019 I-IV | 2020 I-IV | 2021 I-IV | 2022 I-IV |
| | мянган толгой | | | | хувь | | | |
| Дүн | 441.5 | 923.1 | 1 474.3 | 129.5 | 0.66 | 1.30 | 2.20 | 0.19 |
| Адуу | 21.2 | 36.8 | 54.2 | 7.8 | 0.54 | 0.87 | 1.32 | 0.18 |
| Үхэр | 34.0 | 63.1 | 93.7 | 12.3 | 0.78 | 1.33 | 1.98 | 0.25 |
| Тэмээ | 0.4 | 0.3 | 8.6 | 0.2 | 0.09 | 0.06 | 1.83 | 0.03 |
| Хонь | 182.4 | 480.3 | 506.2 | 54.1 | 0.60 | 1.49 | 1.68 | 0.17 |
| Ямаа | 203.6 | 342.7 | 811.6 | 55.1 | 0.75 | 1.17 | 2.93 | 0.21 |

Энэ оны эхний 4 сард Архангай аймагт 22.1 (17.0%) мянга, Хэнтий аймагт 21.8 (16.8%) мянга, Хөвсгөл аймагт 11.8 (9.1%) мянга, Увс аймагт 9.6 (7.4%) мянга, Ховд аймагт 9.1 (7.1%) мянган мал хорогдсон нь нийт хорогдлын 57.4 хувийг эзэлж байна.


ЗУРАГ 1. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, мянга



Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон 30.8 сая эх малын 31.7 мянга (0.1%) нь энэ оны эхний 4 сард хорогдсон байна. Ховд, Увс, Хөвсгөл, Булган, Архангай, Хэнтий аймагт хээлтэгч мал 2.0-7.5 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 65.8 хувийг эзэлж байна. Харин 2.4 мянган хээлтүүлэгч хорогдсоноос ухна 979, хуц 913, бух 364, азарга 125, буур 4 тус тус байна.

Улсын хэмжээнд 2022 оны эхний 4 сард 6.6 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.2 (49.0%) мянгаар өссөн байна.

ЗУРАГ 3. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 92.6 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 2.3 хувь нь аюулт үзэгдлээр, 5.1 хувь нь өвчнөөр тус тус хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.



Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.

Эх үүсвэр:

ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 6 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө
аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн
статистикийн хэлтсийн статистикч
Э.Болормаа
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212